



ХИЛЭЭР НЭВТЭРСЭН ЗОРЧИГЧДЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хот

2018 он

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ХИЛЭЭР НЭВТЭРСЭН ЗОРЧИГЧ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

БҮЛЭГ 2. ХИЛЭЭР ОРСОН ГАДААДЫН ЗОРЧИГЧ, ЖУУЛЧИД

БҮЛЭГ 3. ХИЛЭЭР ГАРСАН ДОТООДЫН ЗОРЧИГЧ


БҮЛЭГ 4. ДҮГНЭЛТ

БҮЛЭГ 1. ХИЛЭЭР НЭВТЭРСЭН ЗОРЧИГЧ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

Монгол Улсад 2017 онд нийт 24 боомт үйл ажиллагаа явуулсан бөгөөд эдгээр боомтуудаар давхардсан тоогоор 5.9 сая зорчигч нэвтэрсэн байна. Улсын хилээр 2017 онд нэвтэрсэн зорчигчдын тоо 2007 оноос 2 дахин, 2012 оноос 31.9 хувиар, өмнөх оноос 9.4 хувиар тус тус өсжээ.

Улсын хилээр нэвтэрсэн нийт зорчигчдын 81.7 хувь нь Монгол Улсын иргэд, 18.3 хувь нь гадаадын зорчигчид, мөн 60.1 хувь нь эрэгтэй, 35.1 хувь нь эмэгтэй, 4.8 хувь нь хүүхэд байна.

Зураг 1. Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигчид, мян.хүн, 2007-2017 он



Улсын хилээр нэвтэрсэн зорчигчдын 79.5 хувь нь авто замын боомт, 3.6 хувь нь төмөр замын боомт, 16.9 хувь агаарын замын боомтоор тус тус нэвтэрчээ.

Хилээр нэвтэрсэн зорчигчдыг боомтуудаар нь ангилан харвал, 38.0 хувь нь Замын-Үүд боомтоор, 16.9 хувь нь Буянт-Ухаа, 12.5 хувь нь Гашуун сухайт, 12.2 хувь нь Алтанбулаг, 5.8 хувь нь Шивээ хүрэн, 14.6 хувь нь бусад боомтоор нэвтэрсэн байна.

Хүснэгт 1. Улсын хилээр нэвтэрсэн зорчигчид, боомтоор, 2017 он


	Гарсан	Орсон	Аяллын зорилго			
			Албан ажлаар	Хувийн журмаар	Байнга оршин суух	Бусад
Бүгд	2 984 320	2 964 029	53 896	184 739	2 430 049	295 345
Алтанбулаг	360 070	366 041	4 484	27 653	318 236	15 668
Арцсуурь	7 762	8 134	6	2 974	5 039	115
Байтаг	308	307	-	2	304	1
Баянхошуу	39 414	38 916	95	1 900	14 954	21 967
Бичигт	58 444	58 213	205	1 403	39 980	16 625

ХИЛЭЭР НЭВТЭРСЭН ЗОРЧИГЧ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЛ, 2017 он

Боршоо	35 912	36 009	223	27 588	8 136	62
Булган	60 531	60 545	127	260	58 315	1 843
Бургастай	11 349	11 374	11	10 895	460	8
Буянт-Ухаа	513 979	494 224	35 182	51 557	264 250	143 235
Гашуун сухайт	372 155	371 638	111	4 139	363 409	3 979
Даян	558	555	22	-	520	13
Замын-Үүд	1 128 884	1 128 640	8 800	28 728	1 037 260	53 852
Сүмбэр	1 192	1 173	10	660	418	85
Сүхбаатар	36 873	30 859	3 853	611	10 741	15 654
Тэс	3 355	3 219	4	2 562	652	1
Ульхан	1 898	1 937	81	290	1 517	49
Хавирга	52 875	52 868	328	1 444	48 836	2 260
Ханги	50 582	50 457	17	1 078	49 233	129
Ханх	21 473	21 431	17	65	12 291	9 058
Ховд	14	13	6	-	1	6
Цагааннуур	47 333	48 152	59	18 314	26 084	3 695
Чойбалсан	105	117	1	2	88	26
Шивээ хүрэн	173 741	173 644	202	1 912	164 560	6 970
Эрэнцав	5 513	5 563	52	702	4 765	44

Улсын хилээр 2017 онд давхардсан тоогоор 2.7 сая тээврийн хэрэгсэл нэвтэрсэн нь өмнөх оноос 436.0 (19.3%) мянгаар өсжээ. Тэдгээрийн 41.5 хувийг ачааны машин, 31.7 хувийг суудлын машин, 24.6 хувийг ачааны вагон, 2.2 хувийг бусад тээврийн хэрэгсэл эзэлж байна.

Зураг 2. Монгол Улсын хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэл, 2017 он




Нийт тээврийн хэрэгслийн 88.4 хувь нь Замын-Үүд, Гашуун сухайт, Шивээ хүрэн, Алтанбулаг, Сүхбаатар боомтоор нэвтэрсэн байна.

БҮЛЭГ 2. ХИЛЭЭР ОРСОН ГАДААДЫН ЗОРЧИГЧ, ЖУУЛЧИД

Монгол Улсын хилээр 2017 онд 2.9 сая зорчигч орсон 542.7 мянга нь гадаадын зорчигчид байна. Энэ нь өмнөх оноос 15.2 хувиар буюу 71.5 мянгаар өсжээ. Тэдний 85.8 хувь нь 30 хүртэл хоног, 12.3 хувь нь 90, түүнээс дээш хоног, 1.9 хувь нь 30-аас 90 хүртэл хоногийн хугацаагаар ирсэн байна.

Гадаадын зорчигчдын 63.7 хувь нь Зүүн Ази, Номхон далайн бүс нутгаас, 30.3 хувь нь Европоос, 4.4 хувь нь Америк тивээс, 1.6 хувь нь Ойрхи Дорнод, Өмнөд Ази, Африк тивээс иржээ.

Зураг 3. Монгол Улсын хилийн боомтуудаар орсон гадаадын зорчигчид, бүс нутгаар, дүнд эзлэх хувиар, 2014-2017



Хилээр орсон гадаадын зорчигчдын 37.2 хувийг БНХАУ-ын иргэд, 20.3 хувийг ОХУ-ын иргэд, 14.1 хувийг БНСУ-ын иргэд, 4.3 хувийг Япон улсын иргэд, 3.3 хувийг АНУ-ын иргэд, 2.7 хувийг Казахстан улсын иргэд, 18.1 хувийг бусад улсын иргэд эзэлж байна. Монгол Улсын хилээр орсон гадаадын зорчигчдыг аяллын зорилгоор ангилан харвал, 86.5 хувь буюу 469.3 мянга нь аялал жуулчлалын зорилгоор, үлдсэн 13.5 хувь буюу 73.4 мянга нь ажиллах, суралцах, байнга оршин суух гэсэн урт хугацааны зорилгоор иржээ.


Зураг 4. Монгол Улсын хилээр орсон гадаадын зорчигчид, жуулчид, сүүлийн 10 жилийн байдлаар, мянган хүн.



Монгол Улсад ирсэн жуулчдын тоог сүүлийн 10 жилийн байдлаар авч үзвэл 2012 онд хамгийн их 475.9 мянган жуулчин ирсэн бөгөөд 2013-2015 онуудад тогтмол буурч 2015 онд хамгийн бага 386.2 мянган жуулчин Монгол Улсад ирсэн бол 2016 онд аажмаар өсөж эхэлсэн нь зураг 4-өөс харагдаж байна. Жуулчдын тоо 2017 онд 469.3 мянга болсон нь өмнөх онуудтай харьцуулахад өссөн үзүүлэлттэй боловч 2010-2012 онуудын үзүүлэлттэй ижил түвшинд байгаа нь Монгол Улсыг зорьж буй жуулчдын тоо өсөлтгүй тогтмол үзүүлэлттэй байгааг харуулж байна.

Монгол Улсад ирсэн нийт жуулчдын 65.0-68.0 хувь нь 2,3 дугаар улиралд буюу 4 дүгээр сараас 9 дүгээр сарын хооронд иржээ. Өвлийн улиралд ирэх жуулчдын тоо бага байгаа нь өвлийн аялал жуулчлал хөгжөөгүй, манай орны хатуу ширүүн уур амьсгалтай холбоотой байх магадлалтай.


Зураг 5. Жуулчдын тоо, улирлаар, сүүлийн 5 жилийн байдлаар, мянган хүн.



Монгол Улсад ирсэн жуулчдын 30.4 хувь нь БНХАУ-аас, 22.8 хувь нь ОХУ-аас, 16.0 хувь нь БНСУ-аас, 4.8 хувь нь Япон улсаас, 3.6 хувь нь АНУ-аас, 3.0 хувь


нь Казахстан улсаас, 2.3 хувь нь Герман улсаас, 2.1 хувь нь Франц улсаас ирсэн, үлдсэн 15.0 хувь нь бусад улс орноос ирсэн байна. Монгол Улсад ирсэн жуулчдын тоог өмнөх онтой харьцуулахад ОХУ, БНСУ-аас ирсэн жуулчдын эзлэх хувь 1.8-2.0 пунктээр, нэмэгдсэн бол харин БНХАУ, Япон, АНУ, Казакстан, ХБНГУ, Франц улсаас ирсэн жуулчдын эзлэх хувь 0.1-2.1 пунктээр буурсан байна.

Зураг 6. Жуулчдын тоо, улсаар, 2016, 2017 он



Монгол Улсад урт хугацааны зорилгоор буюу ажиллах, суралцах, байнга оршин суухаар ирсэн 73.4 мянган гадаадын зорчигчдын 81.0 хувь нь БНХАУ-аас, 4.7 хувь нь ОХУ-аас, 2.7 хувь нь Австрали улсаас, 2.3 хувь нь БНСУ-аас, 1.4 хувь нь АНУ-аас, 1.1 хувь нь Канад улсаас, үлдсэн 6.8 хувь нь бусад улс орноос ирсэн иргэд эзэлж байна. 2017 онд Австрали, АНУ, Канад улсаас ажиллах, суралцах, байнга оршин суух зорилгоор ирсэн гадаадын зорчигчдын эзлэх хувь өмнөх оноос 0.1-0.8 пунктээр өссөн бол харин БНХАУ, ОХУ, БНСУ-аас урт хугацааны зорилгоор ирсэн гадаадын зорчигчдын эзлэх хувь өмнөх оноос 0.3-0.7 пунктээр буурчээ.


Зураг 7. Ажиллах, суралцах, байнга оршин суух зорилгоор ирсэн гадаадын зорчигч, улсаар, 2016, 2017 он



БҮЛЭГ 3. ХИЛЭЭР ГАРСАН ДОТООДЫН ЗОРЧИГЧ

Монгол Улсын хилээр давхардсан тоогоор 2.4 сая Монгол Улсын иргэд гадаадад зорчсон байна. Энэ нь өмнөх оноос 8.3 хувиар өсжээ. Гадаадад зорчсон Монгол иргэдийн 58.8 хувь нь эрэгтэй, 36.3 хувь нь эмэгтэй, 4.9 хувь нь хүүхэд байна. Тэдний 97.7 хувь нь 30 хүртэл хоногоор, 1.5 хувь нь 90-ээс дээш хоногоор, 0.8 хувь нь 30-90 хоногоор зорчжээ. Хилээр гарсан дотоодын зорчигчдын 73.5 хувь нь хувийн, 17.3 хувь нь ажиллах, 4.3 хувь нь жуулчлах, 2.9 хувь нь албан ажлаар, үлдсэн 2.0 хувь нь суралцах, байнга оршин суух, бусад шалтгаанаар гадаадад зорчсон байна.

Зураг 8. Гадаадад зорчсон Монгол иргэд, улсаар, 2017 он



Гадаадад зорчсон Монгол иргэдийн 75.3 хувь нь БНХАУ-руу, 15.9 хувь нь ОХУ-руу, 4.0 хувь нь БНСУ-руу, 1.0 хувь нь Япон улс руу, үлдсэн 3.9 хувь нь бусад

улс орнууд руу зорчжээ. Хилээр гарсан дотоодын зорчигчдыг боомтуудаар нь ангилан харвал, 42.4 хувь нь Замын-Үүд боомтоор, 14.9 хувь нь Гашуун сухайт, 12.8 хувь нь Алтанбулаг, 11.3 хувь нь Буянт-Ухаа, 6.7 хувь нь Шивээ хүрэн, 11.9 хувь нь бусад боомтоор нэвтэрсэн байна.

БҮЛЭГ 4. ДҮГНЭЛТ

Манай улсын хилээр нэвтэрсэн зорчигчдын тоо жил ирэх тусам нэмэгдэж байна. Улсын хилээр 2007 онд 2.9 сая зорчигч нэвтэрч байсан бол 2017 онд 5.9 сая болж 2 дахин нэмэгдсэн байна. 2017 онд нэвтэрсэн нийт зорчигчдын 4.9 сая нь дотоодын зорчигчид байсан ба үүнийг 2007 онтой харьцуулахад 2.5 дахин өссөн үзүүлэлттэй байгаа нь сүүлийн 10 жилийн хугацаанд гадаадад зорчих Монгол иргэдийн тоо хурдацтай нэмэгдэж байгааг харуулж байна.

Хилээр орсон 2.9 сая зорчигчийн 542.7 мянган нь гадаадын иргэд бөгөөд 2007 онтой харьцуулахад 19.3 хувиар, өмнөх оноос 15.2 хувиар өссөн байна. Монгол Улсын хилээр орсон гадаадын зорчигчдыг аяллын зорилгоор ангилан авч үзвэл, 86.5 хувь буюу 469.3 мянга нь аялал жуулчлалын зорилгоор ирсэн нь 2007 онтой харьцуулахад 3.9 хувиар, өмнөх оноос 16.1 хувиар тус тус өсжээ. Монгол орныг зорих жуулчдын тоо сүүлийн 10 жилд өсөлтгүй тогтмол үзүүлэлттэй байгаа нь манай орны хатуу ширүүн уур амьсгал, жуулчлалын улирал богино, жуулчны баазууд дэд бүтцийн хөгжил муу, Монголд хүрэх агаарын нислэг хязгаарлагдмал, үнэтэй, агаарын бохирдол зэрэг олон хүчин зүйлс нөлөөлж байна.

Монгол Улсад ирж буй нийт жуулчдын 65.0-68.0 хувь нь дулааны улиралд буюу 4 дүгээр сараас 9 дүгээр сарын хооронд ирж байгаа нь манай оронд өвлийн аялал жуулчлал хөгжөөгүй, жуулчдыг татах өвлийн арга хэмжээ багатай, мөн манай орны хатуу ширүүн уур амьсгал, агаарын бохирдолтой холбоотой байх магадлалтай.

Монгол орны байгаль, түүх соёл, зан заншлыг сурталчилсан жуулчдыг татахуйц бодлого, хөтөлбөр дутагдаж байгааг, мөн жуулчдын тоог нэмэгдүүлэх арга хэмжээг төр засгаас хэрэгжүүлэх нэн шаардлагатайг сүүлийн 10 жилийн жуулчдын тоо мэдээлэл харуулж байна.

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГЫН ТОВЧОО